



LITE WHITEPAPER

Token created by: **IREEDUI** Gantogtokh



АНХААРУУЛГА:

IZC Whitepaper нь тус токены амбиц, стратеги, “НЭГҮН” Үндэсний олон нийтийн сүлжээ платформ бүтээх, “НЭГҮН” дата төв байгуулах төслийн зорилго, зорилт, төлөвлөгөө зэргийг товч танилцуулах, бизнесийн зураглал, системийг бүрдүүлэхэд токены гүйцэтгэх үүрэг, түүний хэрэглээ, арилжаа, хөрөнгө оруулалтын талаар мэдээллийг хүргэх зорилготой байна.

Танилцуулга нь **IZC** токеныг худалдан авахыг уриалах, гэрээ байгуулахаар төөрөгдүүлэх, хуурч мэхлэх, хүч хэрэглэх зорилгыг агуулаагүй бөгөөд Whitepaper-тай танилцсан нь тус криптовалютыг худалдан авах гэрээний харилцаа үүсгэхгүй.

Төслийн баг нь **IZC** токены үнэлгээ унах, өсөх, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн ажиллагаа доголдох, татвар, хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх болон бусад урьдчилан таамаглаагүй эрсдэл бүхий нөхцөл байдлууд, криптовалютын хоёр дахь зах зээлийн үнэ ханш, тогтвортой, баталгаатай, эрсдэлгүй байдлыг хариуцахгүй.

Хоёр дахь зах зээлийн арилжаанд токены үнэ нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зарчмаар тогтохыг үүгээр анхааруулъя.



АГУУЛГА.

03

Үндсэн мэдээлэл

- 04 Татан төвлөрүүлэлт
- 05 Хуваарилалт
- 06 Удирдлага

09

Roadmap

- 09 Roadmap

10

Удиртгал

- 11 Блокчейн
- 13 IZC токен-ы тухай
- 14 Криптовалют, койн болон токен

18

Нэгүн ҮОНС

- 19 Олон нийтийн сүлжээ гэж юу вэ?
- 21 Дэлхийн жишиг
- 23 Пдатформ танилцуулга
- 40 Алсын хараа

41

Нэгүн дата төв

- 42 Дата төв гэж юу вэ?
- 43 Дата төв танилцуулга.
- 44 Давуу тал, онцлог
- 47 Алсын хараа

48

Төслийн баг

- 48 Төслийн баг



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.

- 1. Токен-ы үүсгэл:** Binance Smart Chain-д үүсгэгдсэн BEP20 стандарт IZC токен
- 2. Токен-ы анхны үнэ:** 1 мөнгө буюу 0.01 төгрөг
- 3. Блокчейнд үүсгэсэн хэмжээ:** 10,000,000,000,000 /арван их наяд/ ширхэг IZC токен
- 4. Нийт токен анхны үнэлгээ:** 100,000,000,000 /нэг зуун тэрбум/ төгрөг
- 5. Олон нийтэд санал болгох /ICO/ тоо ширхэг, хувиар:** 10,000,000,000,000 /арван их наяд/ ширхэг 100 хувийн IZC токен
- 6. Төсөл хэрэгжихэд хөрөнгийн доод хэмжээ:** 2,500,000,000,000 /Хоёр их наяд таван зуун тэрбум/ ширхэг IZC токен буюу 25,000,000,000 /хорин таван тэрбум/ төгрөг.



IZC - IZ COIN - ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

АНХААРАХ: ДОР ЗААСАН ХУГАЦААНД ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН
ДООД ХЭМЖЭЭНЭЭС ИЛҮҮ ЗАХИАЛГА ИРСЭН ТОХИОЛДОЛД АНХНЫ ҮНЭЭР ХУДАЛДАНА.

ТОКЕН УРЬДЧИЛСАН ХУДАЛДАН АВАЛТ /PRE-SALE/-ЫН НӨХЦӨЛ:

2021 оны **11** дүгээр сарын **8** өдрийн **10:00** цагаас **2021** оны **11** дүгээр сарын **25** өдрийн **00:00** цаг хүртэл төгрөгийн хэтэвчиндээ орлого хийсэн үйлчлүүлэгчид урьдчилсан худалдан авалтад оролцоно.

ТОКЕН-Ы ОЛОН НИЙТЭЭС ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХУДАЛДАА /INITIAL COIN OFFERING/:

2021 оны **12** дугаар сарын **1** өдрийн **10:00** цагаас **2021** оны **12** дугаар сарын **10** өдрийн **00:00** цагийн хооронд токены хөрөнгө татан төвлөрүүлэх худалдааг олон нийтэд нээлттэйгээр явуулна.



IZC - IZ COIN - ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Токены хоёр дахь зах зээлийн арилжаа: **2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД.**

/ Жич: Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч биржүүдтэй байгуулах гэрээ, хэлцэл түргэн хугацаанд шийдвэрлэгдсэн тохиолдолд хугацаа наашлах боломжтой. /

ХУДАЛДААЛАГДААГҮЙ ТОКЕН-Ы ХУВААРИЛАЛТ, ТҮГЖИХ НӨХЦӨЛ:

1. ТОКЕН УРЬДЧИЛСАН ХУДАЛДАН АВАЛТ /PRE-SALE/, ОЛОН НИЙТЭЭС ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ /ICO/ НӨХЦӨЛӨӨР ХУДАЛДААЛАГДААГҮЙ ҮЛДСЭН ТОКЕНЫ 50 ХУВИЙГ ТӨСЛИЙН САНААЧЛАГЧ, ЭРХ ХҮЛЭЭН АВАГЧ НЬ 3 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ АРИЛЖАХ, ШИЛЖҮҮЛЭХ ЭРХГҮЙГЭЭР ТҮГЖИЖ, ӨМЧИЛНӨ.

2. ҮЛДЭГДЭЛ 50 ХУВИАС

- ТӨСЛИЙН БАГТ: 1-3 ЖИЛИЙН ТҮГЖЭЭТЭЙГЭЭР 20%
- УРАМШУУЛАЛД: 1 ЖИЛИЙН ТҮГЖЭЭТЭЙГЭЭР 10%
- ХАМТЫН АЖИЛЛАГААНД: 1-6 САРЫН ТҮГЖЭЭТЭЙГЭЭР 10%
- МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛД: 1-6 САРЫН ТҮГЖЭЭТЭЙГЭЭР 10 ХУВИЙГ ТУС ТУС ГҮЙЛГЭЭНД ГАРГАНА.



ТОКЕНЫ УДИРДЛАГА

ТОКЕНЫ УДИРДЛАГА НЬ САНААЧЛАГЧ IZC ТӨСЛИЙН БАГ БӨГӨӨД ДАРААХ БҮТЭЦТЭЙ БАЙНА.

- ТӨСЛИЙН УДИРДАГЧ
- ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС
- САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС
- МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС
- ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ



ТОКЕНООС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ:

ТОКЕН-ООС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН 80 ХУВЬ:

“Нэгүн” Үндэсний Олон Нийтийн Сүлжээ платформыг хөгжүүлэх, “Нэгүн” дата төв байгуулах зорилгоор **“Нэгүн Үндэсний Олон Нийтийн Сүлжээ” ХХК**-ийг үүсгэн байгуулах, дүрмийн сангийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө болгон шилжүүлж албан ёсоор хуулийн этгээдийн статустайгаар үйл ажиллагаа цаашид явуулах болно.

“Нэгүн Үндэсний Олон Нийтийн Сүлжээ” ХХК-ийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслийн худалдан авалт, хөрөнгийн зарцуулалт нь шилэн байх бөгөөд мэргэшсэн аудитын байгууллагын хяналт дор ажиллана.

ТОКЕН-ООС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН 20 ХУВЬ: **IZC ТӨСЛИЙН САНААЧЛАГЧ ӨМЧИЛНӨ.**



ТОКЕН ЭЗЭМШИГЧИД НОГДОХ ӨГӨӨЖ:

- A. Хоёр дахь зах зээлийн арилжаанаас ашиг хүртэх.
- B. **IZC токен**-ы Pre-sale, ICO-с 1,000,000 төгрөгөөс дээш худалдан авалт хийсэн токен эзэмшигч Нэгүн Үндэсний Олон Нийтийн Сүлжээ платформийн баталгаажсан премиум хэрэглэгч болно. Мөн “**Нэгүн**” дата төвд 1 жилийн хостинг байршуулах эрхийг эдлэнэ.
- C. Токен эзэмшигч нь **Нэгүн Үндэсний Олон Нийтийн Сүлжээ платформ**, “**Нэгүн**” дата төвийн үйл ажиллагаа ашиглалт орсон үеэс эхлэн ашгийн **30 хувьтай тэнцэх ноогдол ашгийг** эзэмшиж буй токены хэмжээгээр улирал бүр хүртэнэ.
- D. Токен эзэмшигч нь **IZC savings** буюу заасан хэтэвчинд тогтмол дүнгээр тогтмол хугацаанд токен **HODL** хийж хадгалуулан, тогтоосон ногдол авна.



ROADMAP

2021 оны 11 сарын 6

ICO ПЛАТФОРМ
бие даан хөгжүүлэх

2021 оны 11 сарын 8

УРЬДЧИЛСАН
данс цэнэглэлт

2021 оны 11 сарын 22-25

PRE-SALE буюу урьдчилсан
захиалга эхлүүлэх,
LITE WHITEPAPER
танилцуулах

2021 оны 12 сарын 1

WHITEPAPER болон
ТАНИЛЦУУЛГА ЦАХИМ ХУУДАС
олон нийтэд танилцуулах

2021 оны 12-р сар

ҮНДСЭН ICO буюу
/Initial coin offering/ хийх

2021 оны 12-р сар

“НЭГҮН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ”
ХХК-ийг үүсгэн байгуулах, дүрмийн
сангийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө
болгон шилжүүлж албан ёсоор хуулийн
этгээдийн статустайгаар үйл ажиллагаа
цаашид явуулах.

2022 оны 1-р улирал

2 дахь зах зээлийн арилжаа
хийгдэх

/жич: виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
биржүүдтэй байгуулах гэрээ, хэлцэл түргэн
хугацаанд шийдвэрлэгдсэн тохиолдолд
хугацаа наашлах боломжтой./

2022 оны 2-р улирал

**“НЭГҮН” үндэсний олон
нийтийн сүлжээ** болон
дата төвийн төлөвлөгөөт
ажлыг танилцуулна

2022 оны 3-р улирал

Дата төвийн төлөвлөлт
хийгдэж, бүтээн
байгуулалт эхлэх

2023 оны 1-р улирал

**“НЭГҮН” үндэсний олон
нийтийн сүлжээний**
туршилтын хувилбар
танилцуулах



IZC - IZ COIN

УДИРТГАЛ

2





БЛОКЧЕЙН

Блокчейныг ойлгомжтой байдлаар тодорхойлбол **"Итгэлцэл үгүй ч, шилжүүлгийг боломжтой болгох тогтолцоо"** буюу бидэнд олгож буй үндсэн боломж нь бизнесийн сүлжээнд гүйлгээ бүртгэх, хөрөнгө хянах үйл явцыг хөнгөвчлөх, нээлттэй ил тод, гадны нөлөөнд автдаггүй мэдээллийн сан гэж ойлгож болно

Бүртгэж болох хөрөнгө нь үл хөдлөх хөрөнгө, машин, бэлэн мөнгө, газар гэх мэт биет эсвэл оюуны өмч, патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг зэрэг биет бус байж болно. Үнэ цэнэтэй бүх зүйлсийг блокчейн сүлжээгээр хянаж, арилжаалж болох бөгөөд ингэснээр эрсдэлийг бууруулж, оролцогч талуудын зардлыг бууруулна.



БЛОКЧЕЙН ДАВУУ ТАЛУУД:

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО ШУДАРГА НЭЭЛТТЭЙ (OPEN SOURCE):

Иргэд блокчейн дээр үүсгэсэн өөрийн данс (wallet буюу хэтэвч) болон өөртэйгөө холбоотой хийсэн арилжаа, гүйлгээ, бусад мэдээллийг харах, мөн хэн үзсэн болохыг харилцан мэдэх, мөн нууцлах боломжтой.

КРИПТОГРАФААР ХАМГААЛАГДСАН (CRYPTOGRAPH SECURITY):

Блокчейн дээр орсон бүртгэл, тухайлбал бичиг баримт, мэдээлэл санг өөрчлөх, хуулах, дуурайлгах боломжгүй өндөр зэрэглэлийн криптографаар хамгаалагдсан.

ДУНДЫН БА ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭЭР ДАМЖИХГҮЙ (GLOBAL AND DIRECT):

Энэ нь 2 ба түүнээс дээш тооны хүмүүс хоорондоо шууд мэдээлэл солилцох, гэрээ хэлцэл байгуулах, илгээх, арилжих, гүйлгээнд оролцох гэх мэт дундын шат дамжлагагүйгээр хийгдэх болно.

АШИГЛАХАД ХЯЛБАР, ӨНДӨР ХУРДНЫ ШИЛЖҮҮЛЭГ:

Блокчейн нь хөгжлийн шинэ шатанд гарч их хэмжээний гүйлгээг бага шимтгэлээр өндөр хурдтай баталгаажуулах болсон.



IZC ТОКЕН-Ы ТУХАЙ

Токен-ы төрөл: IZC нь Binance Smart Chain (BSC) блокчэйн платформд суурилсан BEP-20 стандартын токен юм.

Токен-ы нэршил: IZC нь Binance Smart Chain (BSC) блокчэйн платформд суурилсан BEP-20 стандартын токен юм.

Бусад токен-оос ялгарах зорилго, блокчэйн шийдэл ба ашиглалт



КРИПТОВАЛЮТ

Криптовалют нь блокчейн сүлжээ, криптограф гэх өндөр нууцлал бүхий алгоритм хосолсон арилжаа, гүйлгээний зорилго бүхий **виртуал хөрөнгө юм.**

Криптовалют нь **КОЙН, ТОКЕН** гэсэн төрөлтэй байна.

КОЙН



ӨӨРИЙН ШИЙДЭЛ,
БУСДААС ЯЛГАРАХ
ЗОРИЛГООР БҮТЭЭГДСЭН
БЛОКЧЕЙН ЭКОСИСТЕМИЙГ
КОЙН. ТУХАЙЛБАЛ: BITCOIN,
ETHEREUM ГЭХ МЭТ.

ТОКЕН



ХАРИН ТУХАЙН ЭКОСИСТЕМ
ДЭЭР СУУРИЛСАН БУСДААС
ЯЛГАРАХ ӨВӨРМӨЦ
ЗОРИЛГОТОЙ БҮТЭЭГДСЭН
КРИПТОВАЛЮТЫГ ТОКЕН
ГЭНЭ.



IZC ТОКЕНЫ ЗОРИЛГО:

IZC токен нь блокчэйн технологид суурилсан бие даасан, хөрвөх чадвар бүхий токен болохын хувьд дараах зорилготой.

- НЭГҮН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ ПЛАТФОРМ БҮТЭЭХ,
- НЭГҮН ДАТА ТӨВ БАЙГУУЛАХАД ОЛОН НИЙТЭЭС ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ, ХОЁР ДАХЬ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД ГҮЙЛГЭЭНД ГАРГАХ
- НЭГҮН ПЛАТФОРМЫН ОРЧИНД ТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БОЛОХ ГЭСЭН

IZC токены амбиц: Монгол Улсын хамгийн түгээмэл хэрэглээтэй, үнэ цэнэтэй, эзэмшигч болон хэрэглэгчдэд хамгийн өндөр өгөөжтэй койн болох.



IZC ТОКЕН БЛОКЧЕЙН ШИЙДЭЛ БА АШИГЛАЛТ

- НЭГҮН ПЛАТФОРМ ДЭЭРХ ОЛОН ТӨРЛИЙН ХЭРЭГЛЭЭ
- ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРХ БҮХИЙ БИРЖ ДЭЭРХ АРИЛЖАА
- БЛОКЧЕЙНД СУУРИЛСАН, АЮУЛГҮЙ IZC ХЭТЭВЧ
- WALLET ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ
- WALLET-НД ТОКЕН БАЙРШУУЛАН ТӨГРӨГИЙН ФИАТ ҮНЭЛГЭЭТЭЙ ТЭНЦЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ АВАХ
- ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ IZC SAVINGS БУЮУ ЗААСАН ХЭТЭВЧИНД ХАДГАЛАМЖ ҮҮСГЭН ТОГТМОЛ ДҮНГЭЭР ТОГТМОЛ ХУГАЦААНД ТОКЕН ХАДГАЛУУЛАН ТОГТООСОН ХҮҮ АВАХ



IZC НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ

Бид токен-ы үнэ цэнийг өөрийн зорилгод хүрэхийн тулд **1 мөнгө буюу 0.01 төгрөгөөр** тогтоосон. Учир нь аль болох олон нийтийг оролцуулах, **Нэгүн платформын** ашиглалт, орон зайг тэлэх зорилгоор нийтэд хүртээмжтэй байлгахаар шийдсэн.

IZC ӨӨРИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЭКОСИСТЕМТЭЙ.

Үндэсний олон нийтийн сүлжээ **Нэгүн платформ**, түүний экосистемд гүйлгээнд ашиглагдах, виртуал хөрөнгийн төлбөр төлөх, хүү, ногдол, урамшуулал, шагнал, хувь хүн, жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор ашиглагдана.

IZC ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бирж дээр tether криптовалюта, монгол төгрөгтэй фиат байдлаар хөрвөж арилжаанд орно.



IZC - IZ COIN

**IZC ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ҮР ДҮН НЭГҮН ҮНДЭСНИЙ ОЛОН
НИЙТИЙН СҮЛЖЭЭ ПЛАТФОРМ**

3333





ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн өнөөг хүртэл харилцааны тодорхой түвшинд ялгаатай арга, хэрэгслээр дамжуулан бие биетэйгээ харилцаж байна. Анхны харилцааны хэрэгсэл болох тэмдэг, тэмдэглэгээ, дохионоос эхлээд захидал, шуудан, телефон утас, радио, телевизээр дамжуулан харилцан мэдээлэл солилцож ирсэн бөгөөд өнөө үед харилцааны хамгийн оргил хэрэгсэл нь интернет болжээ.

Интернет гэх гайхалтай технологийн шинэчлэлд тулгуурлан олон нийтийн сүлжээ /social network/, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /social media/-ийн олон платформ, шийдлүүд бидний өдөр тутмын амьдралд нэвтэрч, амьдралын салшгүй нэгэн хэсэг болж байна.



ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Харамсалтай өнөөг хүртэл Монгол Улсад үндэсний онцлог, тусгаар тогтносон, хараат бус байдлыг илэрхийлж, агуулсан олон нийтийн сүлжээ байхгүй байгаа ба бид бүхэн Facebook, Instagram, Twitter, Google, Youtube, Wechat зэрэг бусад улс орны бүтээсэн олон нийтийн сүлжээ, платформуудыг ашиглаж байна.

Иймээс бид IZC-ийн хөрөнгө оруулалтаар Монголын анхны Нэгүн үндэсний олон нийтийн сүлжээ платформ төслийг төлөвлөн хэрэгжүүлнэ.



ДЭЛХИЙН ЖИШИГ

ОХУ

 VKontakte

 Odnoklassniki

БНХАУ

 Wechat

 Tencent QQ

БНСУ

 KakaoTalk

 Naver band

Дэлхийн хөгжингүй улс орнууд ихэвчлэн өөрийн гэсэн үндэсний олон нийтийн сүлжээг хөгжүүлэн тогтмол ашигладаг бөгөөд үүний үдсэн зорилго нь улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах болон үндэсний мөнгөн тэмдэгтийн гадагш чиглэх урсгалыг багасгахад орших юм.



НЭГҮН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ ПЛАТФОРМЫН ТАНИЛЦУУЛГА.

“Нэгүн” үндэсний олон нийтийн сүлжээ платформ нь хэрэглээ, агуулгын хувьд дэлхийн чиг хандлагын дагуу ижил төстэй платформууд болох Facebook, Instagram, Twitter зэрэгтэй төсөөтэй байж, дэлхийн технологийн хөгжил, дэвшил, шинэчлэлтэй энэ зэрэгцэн ажиллах болно.

“Нэгүн” үндэсний олон нийтийн сүлжээний цөм нь хэрэглэгчийг тодорхойлох хэсэг буюу profile байна. Улмаар хэрэглэгч төвтэй ЭКО системд үндэслэн хэрэглэгчид бусад хэрэглэгчдэд бүх төрлийн медиа контент үйлчилгээ, худалдаа, оюуны өмчийн хамгаалалттай бараа бүтээгдэхүүн, бүтээлийг хүргэх боломжийг нээх бөгөөд энэ үйлчилгээний үнэлгээ, солилцооны хэрэгсэл нь **IZC токен** байна.



Мөн банкны үйлчилгээ, бүх төрлийн төлбөртэй үйлчилгээ, зар сурталчилгаа, төлбөртэй контент, урамшууллын тогтолцооны үндсэн хэрэглээ нь **IZC токен** байна.
















ДУРСАМЖИЙН САМБАР.

Timeline

Хэрэглэгчид өөрийн бүртгэл дээрх дурсамжийн самбарт өөрийн зураг оруулах, дүрст бичлэг байршуулах, мэдрэмжээ хуваалцах, аудио яриа оруулах, нийтлэл бичих, бараа зарах мэдээлэл, санал асуулга авах тус тус боломжуудтай байна.

 Та ямар дурсамж үлдээх вэ? #Hashtag.. @Mention.. Link.. 

 Зураг хуулах	 Цомог үүсгэх
 Сэтгэл санаа/Үйл явдал	 Өнгөтэй дурсамж
 Аудио тэмдэглэл	 Нийтлэл бичих
 Ямар нэгэн зүйл зарах	 Санал асуулга авах
 Дүрст бичлэг байршуулах	 Аудио байршуулах
 Файл хуулах	

 **Үл мэдэгдэх хүнээр нийтлэх**  **Олон нийтэд** ▾ **Нийтлэх**



ШУУД ДАМЖУУЛАЛТ.

Livestream

Хэрэглэгчид өөрийн утас эсвэл тусгай платформуор дамжуулан өөрийн дүрст бичлэг, аудио яриаг өөрийн найз нөхөд эсвэл бүх хүнд нээлттэй байдлаар шууд дамжуулан олон нийтэд нэвтрүүлэх боломжоор хангагдсан байна.



Шууд дамжуулалт эхлэх



Ганцаараа эсвэл бусадтай хамт



Шинэ! 24 цагийн дотор
автоматаар шууд дамжуулаарай



Үзэгчдээ татахын тулд интерактив
хэрэгслийг нэмнэ үү

Буцах



Шууд дамжуулах




IZC - IZ COIN - НЭГҮН ПЛАТФОРМ

КОНТЕНТ БҮТЭЭГЧИД ТӨЛБӨРТЭЙ ДАГАЖ ТУСГАЙ КОНТЕНТУУД ХАРДАГ ЭРХТЭЙ БОЛОХ.

Digital Creator's subscription system

Нэгүн хуудас нь брэнд, байгууллага, уран бүтээлч, олонд танигдсан контент бүтээгч нарт зориулан дагагч болон дэмжигчид нь тухайн хүмүүсийн контентыг төлбөртэй үзэх эсвэл захиалан тогтмол үздэг байх боломжоор хангагдсан байна.






IZC - IZ COIN - НЭГҮН ПЛАТФОРМ

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮЖИЛТИЙН СИСТЕМ.

Crowdfunding system

Олон нийтээс хандив цуглуулах боломжтой булан байрлах бөгөөд системээс тухайн хандивын зорилго, эх үүсвэр, шалтгаан мөн баттай мэдээлэл дээр суурилан тухайн хандивын үйл ажиллагааг нийтэд зарлаж мөнгө цуглуулах үйл явцыг хянан шалгадаг.







ВИДЕО/АУДИО ДУУДЛАГА.

Video/Audio Calls

Хэрэглэгчид хоорондоо дүрст бичлэг, аудио яриагаар шууд холбогдон хоорондоо харилцдаг байна.





СУРТАЛЧИЛГААНЫ СИСТЕМ.

Advertising system

Нэгүн платформ дээрх хэсгүүдэд хувь хүн, албан байгууллага өөрсдийн мэдээлэл, бараа бүтээгдэхүүнээ төлбөр төлөн сурталчлах боломжтой бөгөөд тухайн төлбөрөөс оногдох цэвэр ашгийн тодорхой хувь нийт IZC эзэмшигч нарт ноогдол ашиг хэлбэрээр тараагддаг байна.






ХЭТЭВЧ.

Wallet

Хэрэглэгч бүрт тусдаа цахим хэтэвч байх бөгөөд тухайн хэтэвч нь 2 ангиллаар ялгаатай байна.

1. Монгол мөнгөн тэмдэгт
2. IZC буюу IZ COIN нь урамшуулал

хэлбэрээр байрших бөгөөд хэрэглэгчид Нэгүн платформ дээр тухайн 2 хэтэвчиндэх дүнгээр үйлчилгээ авах боломжтой байна.





IZC - IZ COIN - НЭГҮН ПЛАТФОРМ

ЗАРЫН СИСТЕМ.

Advertisement system

Хэрэглэгчид өөрт байгаа эд зүйлс, бодит бус зүйлсийг нийтэд нээлттэй хэлбэрээр зарах эсвэл солилцох саналыг үнэ төлбөргүй байршуулах боломжтой байна.

Ганзориг Төгөлдөр зар нэмсэн
хэдхэн секундэд өмнө

Laptop зарна
Central Tower

Америкаас орж ирсэн
HP i5 4th generation 8GB RAM 500GB HDD
14inch
Дагалдах бүрэн
Хэрэглээний програмууд суусан

[Дэлгэрэнгүй үзэх](#)

Төрөл Хуучин	Үнэ ₮900 (MNT)	Төлөв Бэлэн байгаа
------------------------	--------------------------	------------------------------

0 Сэтгэгдэл


Таалах Сэтгэгдэл Хуваалцах



БЛОГУУД.

Blogs

Хэрэглэгчид өөрсдийн мэдлэг, мэдрэмж дээр суурилан өөрсдийн блог хөтлөх боломжтой байх бөгөөд тухайн блогийг Нэгүн платформ дээрх нийт хэрэглэгчид унших, илэрхийлэмж өгөх, бусадтай хуваалцаж сэтгэгдэл бичих боломжоор хангагдана.






IZC - IZ COIN - НЭГҮН ПЛАТФОРМ

OVER THE TOP ПЛАТФОРМУУД.

Over The Top Platforms

Нэгүн платформ дээр оюуны өмчөөр хамгаалагдсан дотоодын болон гадаад контентуудыг ямар нэгэн гацалтгүй өндөр чанартайгаар хүлээн авч үзэх боломжтой байх бөгөөд тухайн контентууд нь төлбөргүй болон төлбөртэй гэж ангилагдана.





БЭЛЭГНИЙ СИСТЕМ.

Gift System

Хэрэглэгчид хоорондоо Нэгүн платформоос санал болгож буй биет болон биет бус бэлгийг бэлэглэх боломжтой бөгөөд тухайн бэлэг нь төлбөртэй байна. Төлбөрийг Нэгүн хэтэвчээр хийх боломжоор хангагдана.





УРАМШУУЛЛЫН СИСТЕМ.

Incentive system

Нэгүн платформ ашиглагчид нь өөрсдийн платформ дээр өгч буй үнэ цэнэ, нөлөөллөөс хамааран IZC буюу IZ Token-г урамшуулал хэлбэрээр хүлээн авч Нэгүн платформ дээр ашиглах эсвэл хэн нэгэн хүнд илгээх боломжтой байх бөгөөд IZC нь бодит арилжааны хэрэгсэл болохгүй.





МЭДЭЭЛЛИЙН ПОРТАЛ.

News portal

Нэгүн платформ нь өөрсдийн бие даасан мэдээлэл хүргэх булантай байх бөгөөд тухайн хэсэгт Монгол улс, Дэлхийн онцлох мэдээллүүдийг ямар нэгэн хаалтын гэрээ, захиалгат бус байдлаар нийтэлж нийт хэрэглэгчдэд хүргэнэ.





ИНТЕГРАЦИ.

Integration

Нэгүн платформ нь дотоодын хувь хүн болон байгууллагад өөрсдийн API-г тодорхой нөхцөл, шаардлагаар ашиглуулах боломжоор хангаж тухайн мэдээллийг өөрсдийн бизнест холбон ашиглах боломжтой байна.






САЙН УУ? ФУНКЦ.

Сайн уу? Функц

Энэхүү функцээр дамжуулан нийт хэрэглэгчид өөрийн огт танихгүй хэрэглэгчидтэй танилцах боломжтой болох бөгөөд хэрэглэгчид тухайн хүмүүстэй санамсаргүй байдлаар таарч бие биедээ адил таалагдсан үнэлэмж өгсөн тохиолдолд тухайн хоёр харилцагч бие биетэйгээ танилцах боломжтой байна. Хэрэглэгчид өөрийн танилцах хүний мэдээллийг ангилах, хязгаарлах боломжоор хангагдсан байна.





ДАВУУ ТАЛ, ОНЦЛОГ, ШИЙДЛҮҮД.

“Нэгүн” үндэсний олон нийтийн сүлжээ бий болгох төсөл нь дараах давуу талыг өөртөө агуулж байна. Үүнд:

- ОЮУНЫ ӨМЧИЙГ БҮРЭН ХАМГААЛЖ, ДЭЛХИЙН БУСАД ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНҮҮДТЭЙ ОЮУНЫ ӨМЧИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАН СОЛИЛЦОЖ, ХАМГААЛНА.
- IZC ТОКЕНЫ ICO-Д ОРОЛЦСОН ИРГЭН БҮРИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН ХУВИЙН ПРОФАЙЛ ҮҮСГЭНЭ.
- “1 ХЭРЭГЛЭГЧ – 1 АККАУНТ” ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН ХЭРЭГЧДЭД ЦОРЫН ГАНЦ АККАУНТ БИЙ БОЛГОХ ЭРХИЙГ ӨГӨХ БӨГӨӨД УЛМААР ХУУЛЬ БУС, ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХ, ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ, ХУУРАН МЭХЛЭХ ЗЭРЭГ НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ЗӨРЧСӨН ҮЙЛДЛИЙГ ҮГҮЙ ХИЙНЭ.



ДАВУУ ТАЛ, ОНЦЛОГ, ШИЙДЛҮҮД.

- НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ТУЛГУУРЛАСАН РЕКЛАМ, ЗАР СУРТАЛЧИЛГААГ ДАГАН ГАДАГШ УРСАЖ БАЙГАА МАШ ИХ ХЭМЖЭЭНИЙ ВАЛЮТЫН УРСГАЛЫГ ДОТООДОО ҮЛДЭЭХ БУЮУ УЛМААР ДОТООДЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛАЛ, ҮР АШИГТАЙ БАЙДЛААР ДЭМЖИНЭ.
- ДОТООДЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ИНТЕГРАЦИ ХИЙХ БОЛОМЖИЙГ НЭЭНЭ.
- ЦАХИМ ОРЧИН ДАХ ХУДАЛ ХУУРМАГ, ЁС БУС, ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ БАГАСГАЖ, ЭЕРЭГ, ГЭГЭЭЛЭГ ОРЧНЫГ ЦОГЦЛООНО.
- ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНД ТАВИГДАХ ДЭЛХИЙН СТАНДАРТЫГ ЖИШИГ БОЛГОН ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ПЛАТФОРМУУДТАЙ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОН АЖИЛЛАХ ШИЙДЛИЙГ БАГТААНА.
- УИХ-ААР БАТЛАГДАХ НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ, ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИУДАД НИЙЦҮҮЛЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА БОЛНО.



IZC - IZ COIN - IZC ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН НЭГҮН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ ПЛАТФОРМ

АЛСЫН ХАРАА.

- ДЭЛХИЙН ТҮВШИНД АЖИЛЛАХ УР ЧАДВАРТАЙ МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАНА.
- “НЭГҮН” ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ НЬ МОНГОЛ ҮНДЭСНИЙ ЦАХИМ ДАРХЛАА БОЛНО.



IZC - IZ COIN

IZC ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН НЭГҮН ДАТА ТӨВ

4444





ДАТА ТӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Дата төв гэдэг нь програм хангамж болон өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх процессыг идэвхжүүлэх тооцоолол бүхий хадгалалтын нөөцийн сүлжээ юм. Дата төв нь бизнесийн хэрэглээг голчлон дэмжих бөгөөд энгийн имэйл, файл солилцохоос эхлээд хэрэглэгчийн CRM систем, байгууллагын нөөц төлөвлөлт /ERP/, big data, харилцаа холбоо, хамтын ажиллагааны бүх үйлчилгээг багтаасан цогц бүтээн байгуулалт юм.



ДАТА ТӨВ ТАНИЛЦУУЛГА.

Мэдээлэл технологийн эрин үед хором, мөч бүрд асах их хэмжээний өгөгдөл, мэдээлэл шинээр бий болж байна. Энэхүү өгөгдөл, мэдээллийг найдвартай, түргэн шуурхай, аюулгүй байршуулан хадгалж, хамгаалах нь нэн тэргүүний шийдэх асуудал болж байна. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор бид орчин үеийн технологийн шийдэлд тулгуурласан олон улсын стандартын дагуу бие даасан өөрсдийн дата төвийг байгуулна.

Дата төвийг Улаанбаатар, Дархан хотуудын аль нэгэнд байгуулахаар төлөвлөж байгаа ба дата төвийг байгуулснаар дараах давуу байдлыг бий болгох боломжтой.



ДАВУУ ТАЛ, ОНЦЛОГ БОЛОН ТЕХНИКИЙН ШИЙДЛҮҮД.

Дата төвд “Нэгүн” үндэсний олон нийтийн сүлжээний өгөгдөл, мэдээлэл хадгалагдах бөгөөд цаашид бидний хэрэгжүүлэх цахим суурьт төслүүдийн цөм бүтээн байгуулалт болно. IZC төслийн хүрээнд дата төв байгуулж, “Нэгүн” үндэсний олон нийтийн сүлжээг байршуулснаар дараах давуу тал бий болно.

- ХАРААТ БУС, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА
- ТЕХНОЛОГИЙН УЯН ХАТАН, ЧӨЛӨӨТ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ БОЛОМЖ.
- НЭГ УДААГИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ИРЭЭДҮЙД ГАРЧ БОЛОХ ИХ ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХЭМНЭСЭН ШИЙДЭЛ.
- ӨНДӨР ХУРДАЙ, ЧАНАРТАЙ, НАЙДВАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭГЧДЭД САНАЛ БОЛГОЖ, УЛМААР УГ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ГАДААД РУУ ГАРЧ БАЙГАА ИХ ХЭМЖЭЭНИЙ ВАЛЮТЫГ ДОТООДДОО ҮЛДЭЭХ БОЛОМЖ.



ДАВУУ ТАЛ, ОНЦЛОГ БОЛОН ТЕХНИКИЙН ШИЙДЛҮҮД.

Төслийн хүрээнд баригдах дата төв нь орчин үеийн техник, технологийн цогц шийдлийг өөртөө багтаах бөгөөд дараах техникийн давуу талуудыг цогцлоосон байна.

ГАЗАР ХӨДЛӨЛТӨД
ТЭСВЭРТЭЙ, ОЛОН
УЛСЫН СТАНДАРТЫГ
ХАНГАСАН БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖ

НАЙДВАРТАЙ
ЦАХИЛГААНЫ
СҮЛЖЭЭ БОЛОН
ОРЧИН ҮЕИЙН
НЭМЭЛТ
ЦАХИЛГААН
ҮҮСГҮҮРИЙН
ЦОГЦ СИСТЕМ

ҮНДСЭН БОЛОН
НӨӨЦ СҮЛЖЭЭНИЙ
ХОЛБОЛТ

ОРЧИН ҮЕИЙН
ХӨРГӨЛТИЙН
СИСТЕМ

ВАКУМЖУУЛАХ
ГАЛ УНТРААХ
СИСТЕМ

ОЛОН ШАТЛАЛТ
ЦАХИМ ХАМГААЛАЛТ



ДАТА ТӨВИЙН АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨӨЛӨЛ ДАРААХ БАЙДАЛТАЙ БАЙНА. ҮҮНД:

- ҮНДСЭН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗАРДАЛ • 36%
- ШААРДЛАГАТАЙ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАРДАЛ • 25%
- ПРОГРАММ, ХАНГАМЖИЙН ЗАРДАЛ • 20%
- АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЗАРДАЛ • 8%
- ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ • 6%
- ЭЛЭГДЭЛ ХОРОГДЛЫН ЗАРДАЛ • 5%



АЛСЫН ХАРАА

Төслийн хүрээнд баригдах Нэгүн дата төв нь ирээдүйд ус, нар, салхины эрчим хүчээр ажиллах “Эко дата төв” болох зорилготой бөгөөд улмаар урсгал зардал буурч, хэрэглэгч, харилцагчдад зах зээлийн үнээс хямд үйлчилгээг санал болгох боломж нээгдэнэ.

- 30 ХУВИЙГ **ӨӨРИЙН ДОТООД ХЭРЭГЦЭЭНД**
- 50 ХУВИЙГ **АРИЛЖААНЫ ЗОРИУЛАЛТААР ТӨЛБӨРТЭЙГӨӨР**
- 20 ХУВИЙГ **START-UP, ШИНЭ ТӨСЛҮҮДЭД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АШИГЛУУЛАХАД ЗОРИУЛНА.**



IZC - IZ COIN

ТӨСЛИЙН БАГ.



Гантогтох **ИРЭЭДҮЙ**

Төслийн санаачлагч, Мэдээллийн технологийн инженер

“МИБОРНИ” ХХК



Батаа **АМАРТҮВШИН**

Технологи хариуцсан захирал

“МИБОРНИ” ХХК



Сайнхүү **ХАЛИУНАА**

Ерөнхий нягтлан

“МИБОРНИ” ХХК



Банди **ХАТАНСАНАА**

Ерөнхий менежер

“МИБОРНИ” ХХК



IZC - IZ COIN

ТӨСЛИЙН БАГ.



Ганзориг **ТӨГӨЛДӨР**

Ахлах График дизайнер

“МИБОРНИ” ХХК



Сүхбаатар **НАРАНБАЯР**

График дизайнер

“МИБОРНИ” ХХК



Пүрэвсүрэн **БИЛЭГЖАРГАЛ**

Олон нийттэй харилцах

“МИБОРНИ” ХХК



Цогбаяр **ЭНХБАДРАЛ**

Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа
үзүүлсэн



Батмөнх **АМАРСАНАА**

Пи Ар медиа зөвлөх

АЙМАР САНАА



БАЯРЛАЛАА!

Token created by: **IREEDUI** Gantogtokh